



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/34/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Оюунтуяа

Утас: 70350757 Цахим хаяг: oyuntuya0428@yahoo.com

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.23 № 09

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН СЭЛЭНГЭ  
ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГА  
М.ЧУЛУУНЗАГД ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>36,853,684.00</u></b>	<b><u>36,584,210.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,210,864.00	2,149,110.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,210,864.00	2,149,110.00
3351	Байгууллагаас авах авлага	2,210,864.00	2,149,110.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	00.00
34714	Томилолтын урьдчилгаа	00.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	34,642,820.00	34,435,100.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	33,547,900.00	33,547,900.00
35110	Тусгай зориулалттай материал	33,547,900.00	33,547,900.00
35130	Эм боох материал	00.00	00.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,094,920.00	887,200.00
35410	Бичиг хэргийн материал	1,094,920.00	862,200.00
35420	Аж ахуйн материал	00.00	25,000.00
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,616,239.57</u></b>	<b><u>14,467,052.41</u></b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	00.00	00.00
<b>371</b>	<b>Урт хугацаат хадгаламж</b>	00.00	00.00
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,616,239.57	14,467,052.41
391	Газар	00.00	00.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5,616,239.57	14,467,052.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	00.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,459,500.00	11,959,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,500,000.00	-3,659,916.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,107,320.00	15,600,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,607,320.00	-10,933,333.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,559,370.84	6,559,370.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,402,631.27	-5,058,568.43
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>42,469,923.57</u></b>	<b><u>51,051,262.41</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>42,469,923.57</u></b>	<b><u>51,051,262.41</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	42,469,923.57	51,051,262.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	00.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	42,469,923.57	51,051,262.41
51210	Өмнөх үеийн үр дүн	42,469,923.57	42,469,923.57
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	8,581,338.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>42,469,923.57</u></b>	<b><u>51,051,262.41</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>114,582,286.00</b>	<b>182,787,525.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>1183</b>	<b>Бусад татвар</b>	00.00	00.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>300,000.00</b>	<b>17,025,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	300,000.00	17,025,000.00
120001	Хувьцааны ногдол ашиг	00.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,000.00	25,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	00.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	25,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>114,282,286.00</b>	<b>165,762,525.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	105,968,000.00	151,245,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	105,968,000.00	151,245,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,314,286.00	14,517,125.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,600,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,000,000.00	14,517.125.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>99,386,423.04</b>	<b>174,206,186.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>99,386,423.04</b>	<b>174,206,186.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	77,993,523.04	161,320,400.32
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	41,094,363.00	97,250,524.00
210101	Үндсэн цалин	31,345,499.00	75,253,688.00
210102	Нэмэгдэл	6,874,264.00	15,934,507.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,874,600.00	6,062,329.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,738,454.00	12,727,195.12
210201	Тэтгэврийн даатгал	3,929,137.00	8,803,577.06
210202	Тэтгэмжийн даатгал	450,772.00	980,905.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	362,154.00	784,724.07
210204	Ажилгүйдлийн даатгал	91,007.00	196,181.17
210205	Эрүүл мэндийн даатгал	905,384.00	1,961,807.58
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,245,300.00	11,038,500.00
210301	Гэрэл, цахилгаан	171,300.00	00.00
210304	Байрны түрээс	5,074,000.00	11,038,500.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,668,541.00	13,121,429.04
210401	Бичиг хэрэг	916,110.00	1,186,920.00
210402	Тээвэр, шатахуун	9,590,000.00	9,942,125.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	588,231.00	1,310,386.04
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	574,200.00	681,998.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,743,200.00	3,810,050.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200.00	178,050.00
210604	Урсгал засвар	1,565,000.00	3,632,000.00

Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,615,400.00	4,846,500.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,615,400.00	4,846,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,008,890.00	5,757,115.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,491,400.00	5,360,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	179,820.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,490.00	85,295.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	66,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,879,375.04	12,769,087.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	1,200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	3,419,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,979,375.04	8,149,187.16
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	21,392,900.00	12,885,785.84
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	00.00	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	21,392,900.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,392,900.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	12,885,785.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	12,885,785.84
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>15,195,862.96</b>	<b>8,581,338.84</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	00.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>15,195,862.96</b>	<b>8,581,338.84</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	45,069,426.59	45,069,426.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>45,069,426.59</b>	45,069,426.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,195,862.96	15,195,862.96
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>42,469,923.57</b>	42,469,923.57
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>42,469,923.57</b>	42,469,923.57
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>42,469,923.57</b>	42,469,923.57
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,581,338.84	8,581,338.84
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>51,051,262.41</b>	<b>51,051,262.41</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>114,582,286.00</b>	<b>165,762,525.00</b>
118301	Бусад татвар	00.00	00.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>300,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>300,000.00</b>	<b>00.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,000.00	00.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	00.00
<b>124</b>	<b>Зээлийн орлого</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр	00.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>114,282,286.00</b>	<b>165,762,525.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>105,968,000.00</b>	<b>151,245,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	105,968,000.00	151,245,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,314,286.00</b>	<b>14,517,125.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,600,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,000,000.00	14,517.125.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>95,477,048.00</b>	<b>165,762,525.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>95,477,048.00</b>	<b>165,762,525.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>74,084,148.00</b>	<b>152,876,739.16</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>41,094,363.00</b>	<b>97,250,524.00</b>
210101	Үндсэн цалин	31,345,499.00	75,253,688.00
210102	Нэмэгдэл	6,874,264.00	15,934,507.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,874,600.00	6,062,329.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,738,454.00</b>	<b>12,727,195.12</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,929,137.00	8,803,577.06
210202	Тэтгэмжийн даатгал	450,772.00	980,905.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	362,154.00	784,724.07
210204	Ажилгүйдлийн даатгал	91,007.00	196,181.17
210205	Эрүүл мэндийн даатгал	905,384.00	1,961,807.58
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5,245,300.00</b>	<b>11,038,500.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	171,300.00	00.00
210302	Түлш, халаалт	00.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	00.00
210304	Байрны түрээс	5,074,000.00	11,038,500.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,738,541.00</b>	<b>12,826,955.04</b>
210401	Бичиг хэрэг	986,110.00	954,200.00

Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	9,590,000.00	9,942,125.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	588,231.00	1,248,632.04
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	574,200.00	681,998.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,743,200.00</b>	<b>3,810,050.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200.00	178,050.00
210604	Урсгал засвар	1,565,000.00	3,632,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,615,400.00</b>	<b>4,846,500.00</b>
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,615,400.00	4,846,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,008,890.00</b>	<b>5,757,115.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,491,400.00	5,360,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	160,740.00	179,820.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	40,750.00	85,295.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	00.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,900,000.00</b>	<b>4,619,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	1,200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	3,419,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,392,900.00</b>	<b>12,885,785.84</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,392,900.00</b>	<b>00.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,392,900.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>12,885,785.84</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	12,885,785.84
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>19,105,238.00</b>	<b>00.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
250005	Төлсөн ногдол ашиг	00.00	00.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>19,105,238.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>19,105,238.00</b>	<b>00.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	151,245,400.00	151,245,400.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	151,245,400.00	151,245,400.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	151,245,400.00	138,659,614.16
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	98,100,100.00	97,250,524.00
210101	Үндсэн цалин	73,177,500.00	73,323,169.47

Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	19,173,300.00	18,659,325.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,749,300.00	5,268,029.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,243,500.00	12,727,195.12
210201	Тэтгэврийн даатгал	9,319,500.00	8,888,341.35
210202	Тэтгэмжийн даатгал	981,000.00	961,296.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	784,800.00	767,501.15
210204	Ажилгүйдлийн даатгал	196,200.00	191,306.17
210205	Эрүүл мэндийн даатгал	1,962,000.00	1,918,750.13
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,456,700.00	11,038,500.00
210301	Гэрэл, цахилгаан	360,800.00	46,100.00
210302	Түлш, халаалт	25,700.00	205,800.00
210303	Цэвэр, бохир ус	24,800.00	297,100.00
210304	Байрны түрээс	11,045,400.00	10,489,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,304,300.00	7,285,830.04
210401	Бичиг хэрэг	530,200.00	530,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,831,800.00	4,825,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,260,300.00	1,248,632.04
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	682,000.00	681,998.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	356,400.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	356,400.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,810,200.00	3,810,050.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200.00	178,050.00
210604	Урсгал засвар	3,632,000.00	3,632,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,738,000.00	2,730,500.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	2,738,000.00	2,730,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,816,300.00	397,115.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,396,900.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	545,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	351,900.00	179,820.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,500.00	85,295.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	66,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3419900.00	3419900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,419,900.00	3,419,900.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө	00.00	00.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	150,502,700.00	151,245,400.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	150,502,700.00	151,245,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	150,502,700.00	151,245,400.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>14,217,125.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>14,217,125.00</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		14,217,125.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		5,541,125.00
210401	Бичиг хэрэг		424,000.00
210402	Тээвэр, шатахуун		5,117,125.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		2,116,000.00
210701	Гадаад албан томиллолт		00.00
210702	Дотоод албан томиллолт		2,116,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		5,360,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		5,360,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	1200000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		00.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	14517125.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		14,517,125.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		14,517,125.00
131106	Төсвийн урамшуулал		00.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Оюунтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Сэлэнгэ голын сав газрын захиргаа нь сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа төрийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсвийн нийт орлогын 1.5 хувиар буюу 2,222.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,555.6 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,851.3 мянган төгрөгөөр буюу 20.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгө байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Дансны авлага	2,210.9	2,149.1	-61.8
Бараа материал	34,642.8	34,435.1	-207.7
Үндсэн хөрөнгө	5,616.2	14,467.0	8,850.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>42,469.9</b>	<b>51,051.2</b>	<b>8,581.3</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	42,469.9	51,051.2	8,581.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>42,469.9</b>	<b>51,051.2</b>	<b>8,581.3</b>

Бараа материалын данс 34,435.1 мянган төгрөг болж 207.7 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэргийн материалын зарцуулалтаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,467.0 мянган төгрөг болж 8,850.8 мянган төгрөгөөр өссөн нь ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг дахин үнэлж нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 51,051.2 мянган төгрөг болж 8,581.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Сэлэнгэ голын сав газрын захиргаа нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 153,933.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 153,933.6 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 151,245.4 мянган төгрөгөөр төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд улсын төсвөөс 151,245.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 138,359.6 мянган төгрөгийг зарцуулж, 12,885.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 138,359.6 мянган төгрөг буюу 91.7 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 849.6 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 516.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 418.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 18.5 мянган төгрөг, норматив зардлыг 356.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 10,419.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14,517.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сэлэнгэ голын сав газрын захиргаа нь 2021 онд нийт 153,933.6 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна, харин зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 73,858.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 2 албан шаардлагын хэрэгжилтийг 80 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	3	52,199.1	3	52,199.1			
Албан шаардлага	2	21,709.2	1	2,8867.4	1	18,841.8	80
Нийт дүн	5	73,858.3	4	55,066.5	1	18,841.8	80

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 415.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант оны шатахууны урамшуулал 268.2 мянган төгрөгийг тайланд тусгаагүй байсаныг залруулав.

### 4.2 Албан шаардлага

Тайлант онд батлагдсан төсвөөс тээвэр шатахуун зарцуулахдаа анхан шатны баримтын бүртгэл хангалтгүй, Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгслийн спидометрийн заалт

ажилладаггүй гэсэн шалтгааны улмаас шатахуун зарцуулалтын тооцоог нормоор бодож баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5.-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6.-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7.-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

###### 1.1 Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэлгүй 415.0 мянган төгрөгний бичиг хэргийн материалыг бөөн дүнгээр зарлагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6."Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7.-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

###### 1.2 Өгсөн зөвлөмж

Анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгах.

Дээрх албан шаардлагын, зөвлөмж биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ голын сав газрын захиргаа	3	683.2	1	268.2			1	0	1	415.0